

ТАНИЛЦУУЛГА

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 13.1-т "Тохирлын үнэлгээний зорилго нь бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, хэрэглэгчийн эрх, ашгийг хамгаалахад оршино", 13.2-т "Тохирлын үнэлгээнд хүн, малын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдал, нийтийн ашиг сонирхолд тохиролт учуруулж болзошгүй бүтээгдэхүүний заавал хамруулна." гэж хуульчилсан.

"Тохирлын баталгаанд заавал хамруулах бүтээгдэхүүн, үйлчилгээний жагсаалт"-ын Гаалийн ерөнхий газраас гаргасан "Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системд үндэслэсэн гадаад худалдааны барааны ангиллын жагсаалт" /БТКУС/-тай нийцүүлэн гаргадаг.

Засгийн газрын 2018 оны 291 дүгээр тогтоолоор баталсан "Тохирлын баталгаанд заавал хамруулах бүтээгдэхүүн, үйлчилгээний жагсаалт"-д БТКУС-ын 50 бүлгийн 182 зүйлийн ба түүнд хамаарах 644 нэр төрлийн бүтээгдэхүүн, мөн 16 үйлчилгээ, 11 төрлийн техникийн хяналтад хамруулах үйлчилгээг тохирлын баталгаанд заавал хамруулахаар заасан. Жагсаалтад хамаарах нийт 644 нэр төрлийн бүтээгдэхүүний 344 буюу 53.4%-ийг 13 баталгаажуулалтын байгууллагууд тохирлын баталгаанд хамруулж байгаа ба 300 нэр төрлийн бүтээгдэхүүнийг тохирлын баталгаанд хамруулахын тулд тухайн салбарт шинээр баталгаажуулалтын байгууллагыг бий болгох, нэмэгдүүлэх шаардлагатай. Мөн нийтийн тээвэр, нийтийн хоолны газар, хүнсний дэлгүүр, бөөний худалдаа үйлчилгээнд баталгаажуулалт хийж буй 3 байгууллага байгаа ба бусад төрлийн үйлчилгээнд одоогоор СХЗГ баталгаажуулалт хийж байгаа ч бүх ААН-ийг хамруулж чадахгүй байна.

Засгийн газрын "Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр авах арга хэмжээний тухай" 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 233 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор "Тохирлын баталгаанд заавал хамруулах бүтээгдэхүүн, үйлчилгээний жагсаалт"-ыг гаргахад ашиглах Гаалийн ерөнхий газрын даргын 2022 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн A/145 дугаар тушаалаар баталсан "Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системд үндэслэсэн гадаад худалдааны барааны ангиллын жагсаалт"-ыг цахим холбоосоор хүргүүлж байна.

Засгийн газрын 2018 оны 291 дүгээр тогтоолоор баталсан "Тохирлын баталгаанд заавал хамруулах бүтээгдэхүүн, үйлчилгээний жагсаалт"-ыг гаргахад БТКУС-ын бүлэг, зүйлээр тогтоон гаргасан нь чухам ямар нэрийн бараа, бүтээгдэхүүнийг тохирлын баталгаанд заавал хамруулах талаар нэр заан гаргаагүй тул уг тогтоолыг хэрэгжүүлэхэд тодорхой хундрэл үүсэж байсан болно.

Иймд жагсаалтын төсөлд санал өгөхдөө Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийг удирдлага болгон зөвхөн тохирлын баталгаанд заавал хамруулах хүн, малын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс

орны аюулгүй байдал, нийтийн ашиг сонирхолд тохиролт учуруулж болзошгүй бүтээгдэхүүнийг сонгон ирүүлэх шаардлагатай байна.

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн дагуу жагсаалтад ороогүй бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч, нийлүүлэгч, хэрэглэгчийн хүсэлтээр тохирлын үнэлгээнд хамруулж болох хуулийн зохицуулалттай.

Мөн Монгол Улсад импортоор оруулж ирэх бараа, бүтээгдэхүүнийг энэхүү тогтоолыг хавсралтаар батлагдах бүтээгдэхүүнийг тохирлын баталгаатайгаар зах зээлд нийлүүлэх, улсын хилээр нэвтрүүлэх журмаар Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 14.2-т заасны дагуу хүлээн зөвшөөрсөн тохирлын болон түүнтэй адилтгах тэмдэг, гэрчилгээтэй жагсаалтад заасан бүтээгдэхүүнийг импортоор нийлүүлж байхаар зохицуулна.

СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР